

“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИ
СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү журмаар Монгол базалт ХК (цаашид “компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журмыг компанийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талууд нэгэн адил дагаж мөрдөнө.
- 1.3. Энэхүү журамд дурьдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1. “Сонирхлын зөрчил” гэж хувь хүний хувийн сонирхол, ажил үүргийн хувьд харшилж болох нөхцөл байдлыг
 - 1.3.2. “Сонирхлын зөрчил бүхий этгээд” Компанийн тухай хуулийн 89.1-д заасныг
 - 1.3.3. “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Компанийн тухай хуулийн 89.2-т заасныг
 - 1.3.4. “Эрх бүхий албан тушаалтан” гэж компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, зохион байгуулалтын нэгжийн удирдлагуудыг
 - 1.3.5. “Сонирхлын зөрчилтэй хэлцэл” гэж сонирхлын зөрчил бүхий этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа групптэй хийж байгаа хэлцлийг

2. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн илрэх хэлбэр

- 2.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл нь дараах хэлбэрээр илэрч болно. Үүнд:
 - 2.1.1. Өөртэйгээ хэлцэл хийх: Компанийн гүйцэтгэх захирал, эрх бүхий этгээдүүд нь хариуцсан ажлынхаа дагуу ямар нэгэн гэрээ, хэлэлцээр байгуулахад өөрөө оролцож, шийдвэр гаргаж ямар нэг байдлаар ашиг олох хэлцэл;
 - 2.1.2. Дотоод мэдээллийг ашиглаж арилжаанд оролцох замаар хийгдсэн хэлцэл: Дотоод мэдээлэлд ойрхон этгээд мэдээллийг өөртөө болон нэгдмэл сонирхолтой этгээдэд ашигтайгаар ашиглаж хийсэн хэлцэл;
 - 2.1.3. Бэлэг, шан харамж авч хийсэн хэлцэл: Эрх бүхий албан тушаалтан нь харилцаанд орж байгаа гуравдагч этгээдээс бэлэг, шан харамж, хөнгөлөлт урамшуулал, бараа үйлчилгээ авсанаар хэлцэл хийх;
 - 2.1.4. Өөр байгууллагад давхар ажил эрхлэхээс үүсэх зөрчил: Компанийн ажилтан, албан хаагч нь өөр компанид ажилладаг, түүний ажиллаж буй байгууллага болон компанийн ашиг сонирхол зөрчилдөхгүй байх;
 - 2.1.5. Гэр бүлийн ашиг сонирхолоос үүсэх зөрчил: Компанийн захирал, эрх бүхий албан тушаалтаны гэр бүл, эцэг, эх, үр хүүхэд зэрэг гэр бүлийн харилцан хамааралтай этгээдэд давуу байдал үүсгэх хэлцэл;

3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам

- 3.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь ТУЗ-д дараах мэдээллийг хэлцэл хийхээс өмнө бичгээр мэдээлж, ТУЗ-ийн зөвшөөрлийг бичгээр авах үүрэгтэй.
 - 3.1.1. Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар
 - 3.1.2. Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар
 - 3.1.3. Компанийн бусад этгээдтэй хийх хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа
- 3.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай шийдвэр гаргахад оролцохгүй. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ-ийн сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналаар гаргана.
- 3.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн бус эрх, мөнгөн хөрөнгө болон бараа ажил үйлчилгээний хэмжээг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйл, Компанийн дүрэмд заасныг баримтлан ТУЗ тогтооно.
- 3.4. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг гагцхүү бичгээр байгуулах ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хэлцлийг бүртгэж, нийтэд мэдээлэх ажлыг хариуцна.
- 3.5. Дараах тохиолдлыг сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцохгүй.
 - 3.5.1. Бүх хувьцаа эзэмшигчид нь хэлцэлд сонирхол бүхий
 - 3.5.2. Хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах эрхээ хэрэгжүүлэх
 - 3.5.3. Хэлцэл байгуулсны дараа нэгдмэл сонирхолтой этгээд болох
 - 3.5.4. Компани хувьцаа эргүүлэн худалдаж авах
 - 3.5.5. Компанийг нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан

Дөрөв. Хариуцлага

- 4.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээд Компанийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээж, компанид учирсан хохиролыг арилгах үүрэгтэй.
- 4.2 Сонирхлын зөрчил бүхий этгээд нь компанид учруулсан хохиролын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээж, өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 4.3 Компанийн хувьцаа эзэмшигч болон ТУЗ, эрх бүхий албан тушаалтан нь буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэж, хохирол төлбөр гаргуулахаар шүүхэд хандах эрхтэй.

--o0o--